

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Г “Юнайтед-Инвесторс” хоршооны хадгаламж, зээлийн г  
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг  
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Хоршооны тухай хуулийн 38.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын гурав дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Юнайтед-Инвесторс” хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН